



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.4 дэххэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцуулах хүсэлт гаргах, баталгаажуулах журам”-ыг 1 дүгээр, “Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцуулах хүсэлт, тооцооны маягт”-ыг 2 дугаар хавсралтаартус тус баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн болон харьяа нэгжийн дарга нарт даалгасугай.

3. Батлагдсан журмыг цахим татварын системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар /Ц.Энхжавхлан/, Татвар төлөгчтэй харилцах газар /Д.Цогзолмаа/, Мэдээллийн технологи, статистикийн төв /Х.Батбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ДЭД ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

**ГАДААД УЛСАД НОГДУУЛАН ТӨЛСӨН АЛБАН ТАТВАРЫГ
ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАРААС ХАСАЖ ТООЦУУЛАХ
ХҮСЭЛТ ГАРГАХ, БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан татвар төлөгчийн гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцуулах /цаашид “албан татварыг хасаж тооцуулах” гэх/, баталгаажуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журам нь Монгол Улсад байрладаг аж ахуйн нэгж, байнга оршин суугч албан татвар төлөгч хувь хүнд хамаарна.

1.3.“Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын хэлэлцээр” /цаашид “Давхар татварын гэрээ” гэх/-д хууль болон энэ журмаас өөрөөр заасан бол уг гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

1.4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасны дагуу гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг улс бүрээр тусад нь тооцно.

1.5.Татвар төлөгч нь албан татварыг хасаж тооцуулах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичиг, тайлан, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг татвар төлөгч өөрөө хариуцна.

Хоёр.Албан татварыг хасаж тооцуулах хүсэлт гаргах

2.1.Татвар төлөгч нь албан татварыг хасаж тооцуулах хүсэлтийг татварын тайлангийн хамт хуульд заасан тайлан тушаах хугацаанд татварын албанд ирүүлнэ.

2.2.Энэ журмын 2.1-д заасан хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

2.2.1.тайлант хугацаанд гадаад улсад албан татвар төлсөн тухай тухайн улсын татварын албанаас гаргасан тодорхойлолт, албан ёсны орчуулгын хамт;

2.2.2.тодорхойлолт нь татварын төрөл, татвар ногдуулах орлогын дүн, төлсөн албан татварын дүн, хугацаа зэргийг агуулсан байх;

2.2.3.гадаад улсын татвар төлөгчийн гэрчилгээ, нотлох баримт бичиг;

2.2.4.гадаад улсын эрх бүхий байгууллагад тайлагнасан татварын тайлан /татварын ногдуулалт, төлөлтийн дүн/;

2.2.5.гадаад улсад албан татвар төлсөн баримтын хуулбар;

Гурав.Албан татварыг хасаж тооцох, баталгаажуулах

3.1.Татвар төлөгч нь албан татварыг хасаж тооцохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу төлбөл зохих албан татварын дүнгийн аль багаар нь тооцно.

3.2.Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн гадаад улсад төлсөн албан татварыг хасаж тооцохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7-д заасныг үндэслэнэ.

3.3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3-т заасан албан татварыг төлбөл зохих албан татварын дүнгээс хасаж тооцохгүй.

3.4.Татварын хялбаршуулсан горимын дагуу татварын албанд бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцохгүй.

3.5.Татварын алба нь татвар төлөгчийн хүсэлтийг хүлээн авч баталгаажуулахдаа “Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам”-ыг баримтална.

3.6.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.28-д заасан татварын жилээс гадаад улсын татварын жил ялгаатай тохиолдолд албан татварыг хасаж тооцуулахдаа мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан хугацаанд багтаан эцсийн тооцоог хийнэ.

3.7.Гадаад улсад ногдуулан төлсөн албан татвараас хасаж тооцох албан татварын хэмжээ нь татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад төлбөл зохих албан татварын дүнгээс хэтрэхгүй бөгөөд илүү гарсан татварыг буцаан олгохгүй, шилжүүлэн тооцохгүй.

3.8.Албан татварын хасалтыг татварын жилд нэг удаа хийх бөгөөд тухайн аж ахуйн нэгж болон хувь хүний орлогын албан татварын жилийн эцсийн тайлан, хавсралт баримт бичигт үндэслэн харьяалах татварын алба нь энэ журмын 3.5-д заасны заасны дагуу хянаж баталгаажуулна.



Монголын Татварын Алба

ГАДААД УЛСАД НОГДУУЛАН ТӨЛСӨН АЛБАН ТАТВАРЫГ
ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАРААС ХАСАЖ ТООЦУУЛАХ
ТООЦООНЫ МАЯГТ

A. Татвар төлөгчийн талаарх мэдээлэл

1. ТТД: | | | | | | | | | | | |

2. Нэр: _____

3. Татвар төлөгчийн одоогийн хаяг:

Аймаг, хот:

Сүм, дүүрэг:

Баг, хороо:

Гудамж, хороолол:

Байшин: _____

Эрхлэх үндсэн үйл ажиллагаа:

Утас:

Факс:

Шүүдэнгийн хайрцаг:

Цахим хаяг:

Хашаа хаалга:

Б.Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварын мэдээлэл: /мянган төгрөг/

Татвар төлсөн улсын нэр	Татвар суутган авсан аж ахуйн нэгжийн нэр	Орлогын ангилал	Татвар төрөл	Татвар ногдуулах орлого	Татвар хувь хэмжээ	Ногдуул сан татвар	Төлсөн татварын дүн

В. Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох тооцоолол: /мянган төгрөг/

Үзүүлэлт	Татвар төлөгч		Татварын алба
Улсын нэр			
Гадаад улсад олсон орлого			
Татварын хувь хэмжээ			
Гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар			
Хасаж тооцох татварын дүн			

Тайланг үнэн зөв гаргасан:

Дарга /захирал/:

..... /

гарын үсэг	нэр
------------	-----

Ерөнхий нягтлан бодогч:

_____ / _____ /

гарын үсэг	нэр
------------	-----

Тайланг хүлээн авсан:

Татварын улсын байцаагч:

..... /

гарын үсэг	нэр
------------	-----

20... оны ... сарын ... өдөр

